

102

Монгол Улсын Дээд Шүүхийн
Хяналтын шатны Захиргааны Хэргийн Шүүхэд
Хүсэлт гаргах тухай

2025.05.28

УБ хот

Иргэн С.Сайнбаяр, М.Ганхишиг бид нар нь Улсын Дээд Шүүхийн Хяналтын Шатны Захиргааны Хэргийн Шүүх хуралдааны 2019.09.23-ны өдрийн 270 дугаартай “ЕАС”ХХК-ийн нэхэмжлэлтэй Байгаль орчин аялал жуулчлалын сайдад холбогдох захиргааны хэргийн тухай” гэх тогтоолыг Захиргааны Хэрэг Хянан Шийдвэрлэх тухай Хуулийн 131-р зүйлийн 131.1.4 дэхь заалтын дагуу шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулахаар дор дурьдсан үндэслэлээр Хүсэлт гаргаж байна. Үүнд:

1.Иргэн С.Сайнбаяр, М.Ганхишиг бид нар нь 1997 оноос ХУД-ийн нутаг дэвсгэрт ХУД-ийн эмнэлгийн хажууд буюу хуучнаар ХУД-ийн 4-р хороо одоогоор ХУД-ийн 23-р хороонд амьдарч байгаа. Тэгээд төрийн захиргааны байгууллагын удаа дараагийн шаардлагаар газраа чөлөөлөн нүүж явсаар 2011онд суурьшин амьдарч байсан газрыг ХУД-ийн 4-р хорооны харьяа болгон бүртгэж 2015 оны хаягжилтаар ХУД-ийн 4-р хороо Арцатын 18-р гудамж 2-28тоот хаягтай болгож бүртгэгдсэн.

2.Тухайн үед 4-р хорооны засаг даргаар ажиллаж байсан Т.Ган-Од нь төрийн болон засаг захиргааны байгууллагуудад хандан ХУД-ийн 4-р хороонд удаан хугацаанд амьдарч буй иргэдийн ашиглаж байгаа газрыг бүртгэлжүүлэх, хаягжуулах талаар арга хэмжээ авч өгөхийг уламжлан оршиг суугч иргэдээс ЗГХЭГазар, Ерөнхий сайд У.Хүрэлсүх, БОАЖЯамны сайд Ц.Цэрэнбат төрийн тусгай хамгаалалттай газрын нутгийн удирдлагын дарга Ч.Батсансар нарт хандан бичиг баримт, өргөдөл гомдлоо тасралтгүй өгсөөр Монгол Улсын Б.О.Н.Х.А.Ж-ын Сайдын 2015.06.12-ны А/235 дугаартай ажлын хэсэг байгуулах тухай тушаал гарсан.

3.Уг тушаалаар Богд Хан Уул дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд хамаарах ХУД-ийн 4-р хорооны иргэдийн ашиглаж байгаа газрыг бүртгэлжүүлэх, гэрчилгээжүүлэх талаар ХУД-ийн 4-р хорооны засаг дарга Т.Ган-Одын 2015.07.06-ны 24тоот албан бичигт нэр дурдсан 27 иргэдэд С.Сайнбаяр, М.Ганхишиг гэж бүртгэгдсэн.

4. Дараа нь 4-р хорооны засаг даргын болон БОНХАЖЯам-ны хамтарсан албан ёсны гэрээтэй “Геоботаник” гэх кадастрын албаны компаниар тухайн үед амьдарч буй айл өрхийн газрыг 2015.06.26-нд кадастрын зураг нийтээр нэгдсэн журмаар хийгдэж Арцатын 18-р гудамж 2-28 тоот 473мкв болон Арцатын 18-р гудамж 2-28б тоотод 473мкв нийт 946мкв газар ашиглах эрх баталгаажин амьдарч байсан.

5. Гэтэл “ЕАС”ХХК нь 2025.04.02-ны өдөр мэдэгдэх хүүдас өгч 2025.04.15-ны дотор компаний ээмшил газрыг чөлөөл гэж мэдэгдсэн тул Нийслэл дэхь Захиргааны Хэргийн Анхан Шатны

Шүүхэд 2025.04.30нд хандан “ Аялал Жуулчлалын Сайдын 2020 оны 02 сарын 18ны өдрийн А/97 дугаартай тушаалаар ХУД-ийн 23-дугаар хороо Арцатын -18 гудамж 2-28 тоотын 473мкв болон 2-286 тоотод орших 473мкв нийт 946мкв газар эзэмших эрхийг “ЕАС” ХХК -д давхцуулан олгосон нь илт хууль бүс болохыг тогтоож С.Сайнбаяр, М.Ганхишиг нарын эзэмшиж байгаа түс бүр 473мкв нийт 946мкв газрыг иргэдэд олгохыг даалгах захиргааны акт гаргах шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан.

б. Тэгтэл маргаан бүхий газрын асуудлаар “ЕАС” ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч Байгаль орчин, Аялал Жуулчлалын сайд, гуравдагч этгээд иргэн Х.Цогзол, Г.Гандэлгэр, Г.Одондалай нарт буюу зөвхөн 1(нэг) гэр бүлийн ашиглаж байсан газрын маргааныг хянан хэлэлцээд Нийслэл дэхь Захиргааны Хэргийн Анхан Шатны шүүхийн 2019.03.06-ны 128/ШШ2019/0151 дугаартай Шийдвэр, Захиргааны Хэргийн Давж Заалдах Шатны Шүүхийн 2019.05.08-ны 221/МА2019/0254 дугаартай Магадлал, УДШ-ийн Хяналтын Шатны Захиргааны Хэргийн Шүүх Хуралдааны 2019.09.23-ны өдрийн 270 дугаартай “ЕАС”ХХК-ийн нэхэмжлэлтэй БОАЖЯамны Сайдад холбогдох захиргааны хэргийн тухай” тогтоол гарч хүчин төгөлдөр болсон байгааг олж мэдсэн.

Иймд маргаан бүхий газарт 2011 оноос амьдарч 2013 онд хорооны бүртгэлд орж, хаягжилт авч, газартаа кадастрын зураг хийлгэн баталгаажуулан гуравдагч этгээдүүдтэй хөрш амьдарч байсан тэдний адил эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа С.Сайнбаяр, М.Ганхишиг нарыг гуравдагч этгээдээр татаж оролцуулаагүйгээр хэргийг хянан шийдвэрлэсэн нь шүүхийн шийдвэрт ноцтойгоор нөлөөлсөн тул шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзнэ үү.

Жич: Холбогдох нийт 34 хуудас баримт хавсаргав.

Хүсэлт гаргасан:

Иргэн



С.Сайнбаяр

Хаяг: Арцатын 18-р гудамж 2-28 тоот

Утас:9602700,94067000



М.Ганхишиг

Хаяг: Арцатын 18-р гудамж 2-286 тоот

Утас:72444248,99016693